

**“ИМПЕРО МАЙНИНГ” ХХК-ИЙН  
(ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ,  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМД)  
ҮЗҮҮРТ ТАЛБАЙН “ЖАЛГА 2”, “ЖАЛГА 3” АЛТНЫ ШОРООН ОРДЫН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ  
/ MV- 022144, РД 6613713/**

2024 он

## ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
<b>1.1. Төслийн ерөнхий мэдээлэл .....</b>	<b>3</b>
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	30
2.1 Байгаль орчны төлөв байдал.....	30
2.2 Нийгэм эдийн засгийн төлөв байдал.....	37
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	40
3.1 Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл.....	42
3.2 Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл .....	42
3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	43
3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл.....	45
3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл .....	45
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл .....	46
3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл.....	46
3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	46
3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	47
3.11 Хуримтлагдах нөлөөлөл.....	47
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	49
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	50
ЗУРГАА.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	52
ДОЛОО.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	64
НАЙМ.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	64
АРАВ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	65
АРВАН НЭГ.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ .....	65
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	68
АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	70

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	71
--	----

## ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл, бичиг баримтын бүрдэл.....	3
Хүснэгт 2. Ашигт малтмалын MV-022144 дугаартай тусгай зөвшөөрөлтэй талбайн захын цэгүүдийн солбилцол .....	8
Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн жагсаалт .....	15
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног .....	16
Хүснэгт 5. Угаан баяжуулах цехийн технологийн усны хэрэглээ.....	18
Хүснэгт 6. Ахуйн ундны усны тооцоо.....	19
Хүснэгт 7. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ.....	20
Хүснэгт 8. Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ .....	21
Хүснэгт 9. Усны нийт хэрэглээний тооцоо .....	21
Хүснэгт 10. RO – 2000L/H маркын ус шүүгчийн техникийн үзүүлэлт .....	25
Хүснэгт 11. Ус ашиглах болон хаяж, зайлуулах, зөвшөөрлүүд.....	25
Хүснэгт 12. Уурхайн эвдрэлд өртөх талбайн хэмжээ .....	26
Хүснэгт 13. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа .....	40
Хүснэгт 14. Гол нөлөөллийн дүн шинжилгээ .....	40
Хүснэгт 15. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ .....	44
Хүснэгт 16. Автомашины утааны бүрдэл найрлага .....	44
Хүснэгт 17. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл .....	47
Хүснэгт 18. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	50

## ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн сансарын зураг .....	10
Зураг 2. Төслийн талбайн байрзүйн зураглал.....	11
Зураг 3. Тусгай зөвшөөрлийн талбайн засаг захиргааны зураглал.....	12
Зураг 4. Уурхайн Ерөнхий дэвсгэр зураг болон ОХШХ-ийг хэрэгжүүлэх цэгүүдийн байршил, авто замын трасс болон олборлолт хийх төлөвлөлт .....	13
Зураг 5. Төслийн МҮ-022144 тусгай зөвшөөрлийн хил доторхи Жалга-3, Жалга-2 нөөцийн блокууд байрласан ерөнхий дэвсгэр зураглал .....	14
Зураг 6. Худгийн байршил.....	23
Зураг 7. Уурхайн тосгоны зураг .....	27
Зураг 8. Газрын гадаргын ерөнхий төрх №1 2022.08.21 .....	28
Зураг 9. Төслийн талбайн ерөнхий төрх -№2 .....	28
Зураг 10. Төслийн талбайн ерөнхий төрх №3 .....	29
Зураг 11. Төслийн талбайн ерөнхий төрх №4.....	29
Зураг 12. Хогийн савны төрөл.....	67

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Империо майнинг” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV-022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТХЭГ-ын даргын 2022 оны 07-р сарын 06-ны өдрийн шийдвэрийн дагуу 30 жилийн хугацаатай эзэмшиж байна.

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл, бичиг баримтын бүрдэл*

Нэг. Төслийн шаардлагатай бичиг баримтын бүрдэл		
1.1	Тусгай зөвшөөрөл:	“Империо майнинг” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлийг АМГТХЭГ-ын даргын 2022 оны 07-р сарын 06-ны өдрийн шийдвэрээр олгосон юм.
1.2	ТЭЗҮ-ийн баталсан тушаал	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 12 сарын 14-ны өдрийн Т/211 тоот тушаал
1.3	Нөөц хүлээж авсан тушаал	Үндэсний геологийн албаны даргын 2022 оны 06 сарын 07-ны өдрийн Н-49 тоот тушаал
1.4	Нөөц хүлээж авсан дүгнэлт	Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт 2022 оны 04 сарын 29-ны өдрийн ХХ-06-05 тоот дүгнэлт
1.5	Багийн Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл:	Баянхонгор аймгийн Өлзийт сумын 4-р багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоол  Баянхонгор аймгийн Өлзийт сумын 4-р багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 07 тоот тэмдэглэл
1.6	Багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоол:	Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 2-р багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 11 дугаар сарын 04-ны өдрийн 10 тоот тогтоол  Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 2-р багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 11 дугаар сарын 04-ны өдрийн 04 тоот тэмдэглэл
1.7	Усны боломжит	“Усны газар”-ын 2022 оны 11 сарын 25-ны өдрийн 04/1282 тоот усны боломжит нөөцийн дүгнэлт

**“Имперо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан**

	нөөцийн дүгнэлт	
1.8	Ерөнхий үнэлгээний дүгнэлт	БОАЖЯ-ны 2022 оны 06 сарын 28-ны өдрийн 13/3650 тоот Ерөнхий үнэлгээний дүгнэлт
1.9	Урт нэртэй хуулийн лавлагаа	Ой, ус, тусгай хамгаалалттай газар нутгийн кадастрын 2022 оны 04 сарын 11-ны өдрийн давхцалгүй лавлагаа.
<b>Хоёр. Төслийн талаарх мэдээлэл</b>		
2.1	Төслийн нэр	Алтны шороон ордыг ил аргаар ашиглах
2.2	Төслийн байршил	<p>Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан байрладаг.</p>  <p>The map displays a topographic view of a mountainous region. A red dashed line delineates the boundaries of the placer sites. A yellow circle marks the location of the 'Erzaltii' river. The map is overlaid with a coordinate grid, with longitude values ranging from 101°17'30"E to 101°23'20"E and latitude values from 45°47'30"N to 45°49'30"N. A legend in the bottom-left corner identifies the yellow circle as 'Эрэлтийн цэг' (Location) and the red dashed line as 'Төслийн талбай' (Project area).</p>
2.3	Зорилго	<p>Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордын нөөцийн ил аргаар ашиглах гол зорилго нь ажилчдыг ажлын байраар хангах, алт олборлон эдийн засгийн эргэлтэд оруулах, Монгол улсын валютын нөөц бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулахад оршино.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улс, Орон нутгийн төсөвт 334 сая төгрөгийн орлого оруулах</li> <li>- Ажлын байрны тоо жилд дундажаар 33 хүний шууд ажлын байр бий болгоно.</li> </ul>

“Империо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

		<p>- Орон нутгаас нийт ажилчдын 40 хувьд нь мэргэшүүлэн ажилд авна.</p> <p>- Байгаль орчны нөлөөллийг бууруулах зардалд жилд дунджаар 8.0 сая төгрөг зарцуулна.</p> <p>- Нөхөн сэргээлтийн зардалд 86.47 сая төгрөг хуримтлуулахаар төлөвлөсөн.</p>										
2.4	Төслийн ерөнхий төлөвлөгөө, ажиллах хуваарь	<p>Уурхайн ажлын горим</p> <p>Уурхайн ажил улирлын чанартай буюу дулааны улиралд 06-р сарын 03-ний өдрөөс 10-р сарын 31-ний өдөр хүртэл 5 сарын хугацаа буюу 150 хоног ажиллах боломжтой. Уурхайн ажлын горимыг жилд амрах баяр ёслолын хоног, цаг агаарын хүндрэлийн хоног, мөн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хоногуудыг тус тус оруулсан байна.</p> <p>Ажилчдын орон тоо, цалингийн зардал (сан)</p> <p>Алтны шороон орд ашиглах төсөл хэрэгжих хугацаанд зуны улиралд вахтын системээр 5 сар ажиллах ба уурхайд нийтдээ 33 хүн ажиллах юм. Хоногт 10 цагийн 2 ээлж ажиллах учир ажиллагсад ажлын хоног бүрд 2 цагийн илүү цагийн хөлс олгох юм. Ажиллах хугацаанд ажиллагсдын сарын дундаж цалин илүү цаг тооцсоноор 250.43 мянган төгрөг болж байгаа.</p> <p>Байгууллага нийгмийн даатгалын шимтгэлд 33.81 сая төгрөг жилд төлнө. Ажиллагсдын цалингаас 12.86 сая төгрөгийг хүн амын орлогын албан татварт суутгаж, төсөвт төлнө.</p> <p>Ил уурхайн хүчин чадлыг харгалзан авто-тээвэртэй гадаад, дотоод овоолготой ашиглалтын системийг сонгон авсан байна.</p>										
2.5	Хүчин чадал	<p>Төслийн хүчин чадал, орд ашиглалтын хугацаа</p> <p>Олборлолтын 1 жилийн хугацаанд нийт 26.02 га талбайг эзлэх 33.61мян м3 эзлэхүүн бүхий шимт хөрс хуулж хөрсний овоолгын хойд талд байршуулна. Гадаад овоолгын доголын өндөр 1.5 м, налуу 65 хэм байна.</p> <p>Уурхайн эвдрэлд өртөх талбайн хэмжээ</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Эвдрэл үүсэх талбай</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Хэмжээ</th> <th>Эвдрэлийн шинж</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ил уурхай</td> <td>га</td> <td>14.6</td> <td>Уурхайн олборлолтын үйл ажиллагааны</td> </tr> </tbody> </table>	№	Эвдрэл үүсэх талбай	Хэмжих нэгж	Хэмжээ	Эвдрэлийн шинж	1	Ил уурхай	га	14.6	Уурхайн олборлолтын үйл ажиллагааны
№	Эвдрэл үүсэх талбай	Хэмжих нэгж	Хэмжээ	Эвдрэлийн шинж								
1	Ил уурхай	га	14.6	Уурхайн олборлолтын үйл ажиллагааны								

“Импери майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

					улмаас эвдэгдэнэ.
	2	Шимт хөрсний овоолго	га	2.09	Овоолго үүсгэж эвдэгдэнэ
	3	Баяжуулах хэсэг	га	2.34	Угаах төхөөрөмж, Нуур, далан
	4	Хөрсний гадаад овоолго	га	0.1	Ил уурхайн үйл ажиллагааны улмаас үүснэ.
	5	Уурхайн тосгон, засварын цех	га	0.5	Барилга байгууламжийн улмаас эвдрэлд орно
	6	Технологийн зам	га	4.39	Хөрс, элс тээврийн үед үүсэх технологийн зам
	7	Бусад	га	2.0	Гар аргаар алт олборлогчдын улмаас эвдэрсэн газар
	Нийт		га	26.02	
2.6	Төслийн хог хаягдал	<p>Хатуу хог хаягдал:</p> <p>Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор жилд 4.3 тн орчим хаягдал гарах бөгөөд харьяа сум багийн холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна.</p> <p>Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.</p> <p>Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт</p> <p>Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд</p> <p>Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал</p>			

		<p>/компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.</p> <p>Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай</p> <p>Шингэн хог хаягдал:</p> <p>Нийт 33 ажилтантай гэж үзвэл хоногт 1.52 м<sup>3</sup>, жилд амралт баяр ёслолын өдрийн хасаад 150 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 1128.0 м<sup>3</sup>/жил болно. Соруулдаг бохирын ёмкоостой болно.</p> <p>Хийн хаягдал:</p> <p>Үйлдвэрийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.</p> <p>Уурхай ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 120.81 тонн дизель түлш зарцуулахад хөө – 1.87 тн, СО-0.00001208 тн, нүүрстөрөгч-3.6243 г, NO<sub>2</sub>-0.00005927 тн, SO<sub>2</sub>-0.00000242 тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 1.871 тн хорт хий ялгарахаар байна.</p>
2.7	Ариун цэврийн байгууламж	Ажилчдын гэр кемп дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай бөгөөд байгаль орчин, ариун цэврийн цаасыг зөв зохистой ашиглах, хувийн ариун цэвэр сахих соёлын тухай санамжуудыг байрлуулж ба экологийн боловсролын булан бий болгосон.
2.8	Усан хангамж	Тус уурхай нь өөрийн гүний худагтай.
2.9	Цахилгаан хангамж	Дизель генератор: Denyo DCA-220SPK3 220 кВт 1ш, Denyo DCA-180SPK3 125 кВт 1ш,
2.10	Дулаан хангамж	Улирлын чанартай ажиллах тул дулаан хангамж шаардлагагүй.

Судалгааны объектын товч танилцуулга



Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон орд нь III бүлэгт хамаарах бөгөөд ордын хэмжээнд тогтоогдсон алтны боломжтой нөөц С зэрэглэлийн химийн цэврээр нийт 10.46 кг, В зэрэглэлийн химийн цэврээр нийт 10.36 кг байна. Ордын хэмжээнд хөрсний дундаж зузаан 1.43 м, элсний дундаж зузаан 0.43 м, дундаж агуулга 167 мг/м3 болно.

Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны явцад үйлдвэрлэлийн нөөцөөр нийт 211.8 мян.м3 хөрс хуулалт, 88.7 мян.м3 элс олборлоно. Гадаад овоолгод 33.61 мян.м3 шимт хөрс, 1.8 мян.м3 хөрс гадаад овоолгод байрших ба үлдсэн 210.0 мян.м3 хөрс дотоод овоолгод байршуулахаар тооцсон болно.

Ил уурхайн хүчин чадлыг харгалзан авто-тээвэртэй гадаад, дотоод овоолготой ашиглалтын системийг сонгон авлаа.

ТЭЗҮ үнэлгээгээр: Тус төсөл нь зуны улирлын 5 сар ажиллах ба уурхай, угаах төхөөрөмжинд нийтдээ хүн ажиллах юм. Эхний жилд 4 сарын 1 нээс нийт 33 хүн ажилчид авах ба оны сүүлийн 3-4 сард сул зогсоно гэж тооцоолов.

## 1.2 Төслийн байршил

Судалгааны талбай нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын төвөөс урагш 19 км, Баянхонгор аймгийн Өлзийт сумын төвөөс зүүн урагш 46 км-т оршино. “Үзүүрт” нэртэй MV-022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 1027.27 га бүхий талбайг хамран байр зүйн зургийн L-47-83 хавтгайд байрлана.

Ашиглалтын нийт талбайн 95 хувь нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутаг дэвсгэрт, 5 хувь нь Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт тус тус хамааргдаж байна.

Газрын байршил орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 2 км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлага хангаж байна.


Хүснэгт 2. Ашигт малтмалын MV-022144 дугаартай тусгай зөвшөөрөлтэй талбайн захын цэгүүдийн солбилцол

№	Өргөрөг	Уртраг
	х	у
1	101° 18' 58.29"	45° 49' 40"
2	101° 18' 12.82"	45° 49' 40"
3	101° 18' 12.82"	45° 49' 14.3"
4	101° 18' 35.69"	45° 49' 14.3"
5	101° 18' 35.69"	45° 48' 58.19"
6	101° 18' 59"	45° 48' 58.19"
7	101° 18' 59"	45° 48' 42"
8	101° 18' 12"	45° 48' 42"
9	101° 18' 12"	45° 48' 10"


“Импери майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

10	101° 19' 39"	45° 48' 10"
11	101° 19' 39"	45° 47' 36.65"
12	101° 18' 46.1"	45° 47' 36.65"
13	101° 18' 46.1"	45° 47' 16"
14	101° 20' 12"	45° 47' 16"
15	101° 20' 12"	45° 48' 11"
16	101° 21' 5"	45° 48' 11"
17	101° 21' 5"	45° 47' 46"
18	101° 21' 57"	45° 47' 46"
19	101° 21' 57"	45° 47' 27"
20	101° 22' 40"	45° 47' 27"
21	101° 22' 40"	45° 48' 0"
22	101° 22' 31"	45° 48' 0"
23	101° 22' 31"	45° 48' 19"
24	101° 20' 28.5"	45° 48' 19"
25	101° 20' 28.5"	45° 48' 57"
26	101° 19' 52"	45° 48' 57"
27	101° 19' 52"	45° 49' 20"
28	101° 18' 58.29"	45° 49' 20"

“Имперо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан




Зураг 1. Төслийн талбайн сансарын зураг




Зураг 2. Төслийн талбайн байрзүйн зураглал

“Имперо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан




Зураг 3. Тусгай зөвшөөрлийн талбайн засаг захиргааны зураглал

“Имперо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан



Зураг 4. Уурхайн Ерөнхий дэвсгэр зураг болон ОХШХ-ийг хэрэгжүүлэх цэгүүдийн байршил, авто замын трасс болон олборлолт хийх төлөвлөлт

“Импери майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших МУ- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан



Зураг 5. Төслийн МУ-022144 тусгай зөвшөөрлийн хил доторхи Жалга-3, Жалга-2 нөөцийн блокууд байрласан ерөнхий дэвсгэр зураглал

Төслийн талбайн байршил, онцлог. Судалгааны талбай нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын төвөөс урагш 19 км, Баянхонгор аймгийн Өлзийт сумын төвөөс зүүн урагш 46 км-т оршино. Талбайн хэмжээ нь 1027.27 га.

Одоогоор төслийн талбайд үйл ажиллагаа явуулаагүй байна. Цаашид тус төслийн талбайд хүний үйл ажиллагаа болон техник технологийн нөлөөгөөр газрын эвдрэл ихсэж болзошгүй тул төслийн бүх шатанд анхаарч ажиллах шаардлагатай. Тээвэрлэлтийн үед тогтоосон маршрутын дагуу явах, ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулахыг зөвлөж байна.

### 1.3 Ил уурхайн хүчин чадал

Уурхайн хүчин чадал, орд ашиглах хугацааг Захиалагч компанийн өгсөн техникийн даалгаварын дагуу ордыг 1 жилийн хугацаанд ашиглах бөгөөд В зэрэглэлийн 10.46 кг алт болон 88.7 мян.м3 элс олборлоно.

### 1.4 Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа, урьд нь ашиглагдаж байсан тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлана.

### Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр, марк	Үзүүлэлт	Ашиглалтын жил	Өмчлөлийн хэлбэр
1	Экскаватор – Liebherr R-924	1.25 м.куб	2	Өөрийн
2	Автосамосвал – North benz 2527k	20 тн	4	
3	Бульдозер – Shantui SD23	6.5 м.куб	1	
4	Утгуурт ачигч – XGMA-XG955H	3.0 м.куб	1	
5	Усны машин – Майти	5 тн	1	
6	Түлшний машин – Майти	5 тн	1	

### 1.5 Ил уурхайн ажиллах горим, ашиглах хугацаа, цалингийн сан

Уурхайн ажил улирлын чанартай буюу дулааны улиралд 06-р сарын 03-ний өдрөөс 10-р сарын 31-ний өдөр хүртэл 5 сарын хугацаа буюу 153 хоног ажиллах боломжтой. Уурхайн ажлын горимыг жилд амрах баяр ёслолын хоног, цаг агаарын хүндрэлийн хоног, мөн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хоногуудыг тус тус оруулан тооцлоо.



Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног

№	Үзүүлэлт	Утга
1	Жилийн календарийн хоног	153
2	Жилд амрах хоног	3
	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ	7
	Болзошгүй цаг агаарын хүндрэл	7
3	Жилд ажиллах хоног	138
4	Хоногт ажиллах ээлжийн тоо	2
5	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12

1.7 Орд нээх ба ашиглах тооцоо

Ил уурхайн төлөвлөлт

Ил уурхайн төлөвлөлтийг ил уурхайн хүрэн дэх нөөцөд тулгуурлан хийлээ. Олборлолтын төлөвлөгөөг боловсруулахдаа блокуудыг нэг талаас нь хөөх маягаар уулын ажлыг явуулахаар тооцсон.

Ашиглалтын технологи. Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордын уул техникийн нөхцөл үзүүлэлтээс харахад тус орд нь хөрсний хурдас нь том бул чулуу, цэвдэгшил байхгүй, уул техникийн нөхцөл сайн, гидрогеологийн нөхцөл энгийн тогтоцтой, хамгийн ихдээ 3.0 метр хүртэлх ухаш үүснэ. Ашигт давхарга нь босоо байрлалаараа улирлын хөлдөлтөнд бараг ордоггүй учир уул-геологийн хувьд олборлолтын явцад онцын хүндрэл үүсэхгүй. Тиймээс уурхайг бусад шороон ордын жишгээр ил аргаар тээвэртэй-гадаад болон дотоод овоолго хослосон ил уурхайн ашиглалтын системээр ашиглахаар сонголоо.

Уурхайн нээлт: Ордыг гадаад туслах траншейгаар “Жалга-2” хэсгийн С-6 блокоос эхлэн нээж С-5, С-4, С-3 дарааллаар олборлоно. Гадаад туслах траншей замын өргөн 10 м, замын налуу 90 промилль байна. Уурхайн нээлтийн ажлаар гарах хөрсийг С-6 блокын баруун хэсэгт байрлах дунджаар 1.0 м гүнтэй, 1.03 га бүхий гар аргаар алт олборлогчдын үүсгэсэн ухаш хэсэгт дотоод овоолгод байршуулах ба шимт хөрсийг экскаватор, автосамосвалын тусламжтай зөөж уурхайн хүрээний гадна 30-40 м-ийн зайд овоолно.

Уржил шимт хөрс хуулалт: Ордын ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.2 метр зузаантайгаар экскаватор, автосамосвалын тусламжтай уурхайн хүрээний гадна 30-40 м-ийн

зайд зөөн овоолж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглана. Шимт хөрсний овоолгын өндөр нь 2.0 м байх бөгөөд хажуугийн тогтворжилтын өнцөг нь 35 градус байна. Шимт хөрсийг хуурай сэрүүний улиралд хуулах нь тохиромжтой бөгөөд овоолгыг аль болох нөмөр газар хийх ба тийм боломжгүй тохиолдолд шимт хөрсний овоолгыг сууж дагтарштал нь тусгай зориулалтын торон хучилт хийж салхи шуурганд хийсэхээс сэргийлэх болон ургамалжуулж болно. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна.

Хөрс хуулалтын ажил: Ил уурхайг нээх буюу эхлэх үед хөрсний чулуулгийг экскаватор - автосомасвалын хослолоор олборлолтын талбайн гадна гадаад овоолго хийнэ. Ийнхүү хөрс хуулалт болон элс олборлолтыг явуулж тухайн хэсэгт тодорхой хоосон орон зай гаргаж, дараагийн олборлолтын блокийг гарсан орон зайд экскаватор-автосомасвалын хослолоор зөөвөрлөн дотоод овоолго хийх замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ. Хөрс хуулалтын ажлын доголын өндөр 5 м байна. Хөрсний гадаад овоолгын доголын өндөр 2-10 м, доголын налууугийн өнцөг 35 градус байна.

Элс олборлолтын ажил: Элс олборлолтын догол, мөргөцгийн өндөр нь мөн элсний давхаргын зузаанаас шалтгаалж уурхайн дунджаар 1.1 м байна. Олборлолтын ажлыг экскаватор, автосомасвалын хослолоор ухаж ачин тээвэрлэж баяжуулах төхөөрөмжийн дэргэд байрлах элсний түр овоолгод овоолно.

## 1.8 Уурхайн дэд бүтэц

### 1.8.1 Цахилгаан хангамж

Цахилгаан хангамж Дизель генератор: Denyo DCA-220SPK3 220 кВт 1ш, Denyo DCA-180SPK3 125 кВт 1ш,

### 1.8.2 Дулаан хангамж

Улирлын чанартай ажиллах тул дулаан хангамж шаардлагагүй.

### 1.8.3 Усан хангамж

“Үзүүрт” нэртэй тусгай зөвшөөрлийн талбайн “Жалга-2” хэсгийн шороон ордын талбайд хайгуулын 28 болон 26-р шугмын дунд хэсэгт 2021 онд өрөмдсөн АХ-01\2021 дугаартай ашиглалтын худгийн мэдээллийг ашиглан ордын гидрогеологийн нөхцөл, уст давхаргын усжилтын зэрэг, уулын малталтанд орж ирэх газрын доорх усны урсацын тооцоо болон ордын дэвсгэр талбайд тархсан дээд плейстоцены настай сэвсгэр хурдасны зузаалаг дахь уст давхарга болон неопротерзойн настай гүний чулуулгийн ан цавын бүсийн газрын доорх усны боломжит нөөц, баялгийг үнэлэх боломжтой болсон байна.

Гидрогеологийн цооногийн гүн нь 70.0 м, цооног дахь усны тогтонги түвшин 3.5 м, уст үеийн байрлал нь 3.5- 8.9 м, 45.0-60.0 м гүнд байрлана. Цооногийн ундарга 15.0 л/сек, түвшний

бууралт 40.0 м болно. АХ-01\2021 дугаартай ашиглалтын худагт гүйцэтгэгч компани туршилт шавхалтын ажлыг хийж дуусгаад, цаашдын хэрэглээнд зориулан битүүмжлэн үлдээсэн байна. /Худгийн паспортыг хавсаргав/

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах юм. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны санг байгуулна.

Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ. Төслийн уурхайн хэмжээнд хуримтлагдах хөрсний ус болон гүний усаар хангахаар төлөвлөжээ.

#### 1) Технологийн усан хангамж, усны хэрэглээ

Баяжуулах үйлдвэрт хэрэглэгдэх нийт усны хэрэгцээ нь элс баяжуулах үйлдвэрийн технологийн ба унд ахуйн хэрэгцээний зориулалтын уснаас бүрдэнэ. Технологийн усны гол хэрэглэгч нь угаан баяжуулах төхөөрөмж бөгөөд түүнийг угаалгын эхэнд нийт шаардагдах усаар 100% хангаж өгөх ба цаашид 75% эргэлтийн ус, үлдсэн 25% усаар нөхөгдөн тэжээгдэнэ.

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах юм. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны санг байгуулна.

Үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах юм.

Ордын элс нь дунд зэргийн угаагдах шинж чанартай учир 1м<sup>3</sup> элс угаахад 4.0м<sup>3</sup> ус хэрэглэхээр тооцоолов. Тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт шүүрэлтээс болж алдагдал гардаг. Иймд уг алдагдлыг гадаад эх үүсвэрээс цэвэр усаар нөхөж, худгийн түвшнийг тогтмол барьж байх шаардлагатай.

#### Хүснэгт 5. Угаан баяжуулах цехийн технологийн усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд	
			Эхний жил	Нийт ажлын хэмжээ
1	Угаах элсний хэмжээ	мян.м <sup>3</sup>	88.7	88.7
2	1 м <sup>3</sup> элс угаахад зарцуулах усны хэмжээ	м <sup>3</sup>	4.0	4.0

“Империо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

3	Жилийн усны алдагдал	мян.м3	11.07	11.07
4	Технологит зарцуулах нийт усны хэмжээ	мян.м3	354.8	354.8
	Цэвэр усны хэмжээ 25%	мян.м3	87.7	87.7

ТЭЗҮ-ээр нэг жилд олборлож дуусах бөгөөд нийт үйлдвэрлэлийн нөөцөөр 88.7 мян.м3 элс угаан баяжуулна. 1м3 элс баяжуулахад 4.0 м3 ус шаардлагатай гэж үзвэл нийт 354.8 мян.м3 ус болж байгаа ба үүний 75 хувийг эргэлтээр 25 хувийг нэмэлтээр шаардлагатай гэж үзвэл 266.1 мян.м3 эргэлтээр, 87.7 мян.м3 нэмэлтээр сэлбэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл уурхайн үүсмэл нуурыг 0.02 л/сек-ээр усыг сэлбэж байх шаардлагатай байх бөгөөд үүнд дээрх зайлуулах усны ундарга хангалттай байна.

2) Ундны болон ахуйн усан хангамж, усны хэрэглээ

Ахуйн хэрэглээний усны тооцоо: Уурхайд нийт 33 хүн ажиллана.

Нэг хүний ус хэрэглээний норм хоногт ажлын болоод ахуйн хэрэгцээнд дунджаар 80л орчим байна. Уурхайн ахуйн усыг худагас зөөж хангана. (\* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт –“Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр – 80л/хоног/хүн)

Хүснэгт 6. Ахуйн ундны усны тооцоо

№	Үзүүлэлтүүд	Норм, л/хоног	Хүний тоо, ш	Усны зарцуулалт		
				м3/хоног	Жилд ажиллах хоног	мян.м3/жил
1	Ахуйн усны хэрэглээ	80	33	2.64	153	403.92

3) Зам талбайн усны хэрэглээ

БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан ус хэрэглээний нормын 13-р хавсралтын дагуу 1 м2 гудамж, зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэгцээг тодорхойлбол. Уурхайн дотоод тээврийн зам 12000 м2, хоногт 1 удаа услах ба жилд цэвэр ажиллах 138 хоног /1 жил дэхь ажиллах хоног/ усална гэж тооцоо.

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4 цаг тутамд явуулна (зөвхөн өдрийн цагаар). Автоцистерн тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замд хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Тоос дарах ажлыг тоноггосон нэг усалгааны машин гүйцэтгэнэ (ТЭЗҮ., 2022). Эвдрэлд өртөх 4.39 га технологийн зам байна. (ТЭЗҮ., 2022, хуу116)

Хоногт хэрэглэх усны тооцоо:

$$43900 \text{ м}^2 \cdot 2.0 \text{ л/хон} \cdot 1 \text{ удаа} = 87.8 \text{ м}^3/\text{хоног}$$

Жилд хэрэглэх усны тооцоо:

$$87.8 \text{ м}^3 \cdot 138 \text{ хон} = 12,116.4 \text{ м}^3/\text{жил}$$

Хүснэгт 7. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ

Ашиглалтын жил	Жилд услах зам, м2	1 м2 замын усалгаанд шаардагдах ус, литр	м3/хоног г	м3/жил 138 хоног ажиллана	Ундарга, л/сек
Жилд	43900.0	2.0	87.8	12,116.4	1.06
Нийт ашиглалтын 1 жилийн хугацаанд				12,116.4	

4) Биологийн нөхөн сэргээлтийн усны хэрэглээ

Төслийн ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 26.02 га талбай нөлөөлөлд өртөх ба техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг уурхайн ашиглалтын сүүлийн жилд хийгдэх юм. Уурхайг бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээж, уурхайн тосгон орчмын 0.5 га (5000.0 м2) талбайд мод, бут тарих зэрэг биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн байна.

Нөхөн сэргээлтэнд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 11-р хавсралтын дагуу 2 настай навчит модыг 40 л/мод нормоор, олон наст ургамлаар нөхөн сэргээсэн талбайг 4 л/м2 нормоор услахаар тооцлоо. Усалгааг 7 хоногт 1 удаа хийнэ.

БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-301 дугаар тушаалаар батлагдсан нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу тарилт, суулгалт хийсний дараа нөхөн сэргээлтэд тарьсан ургамлыг бие даан ургах чадвартай болтол нь усалж арчилна гэж заасан байдаг. Усалгааг газрын гадаргын налуу, хэлбэржилт, байрлал, цаг уурын нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хийх ба ялангуяа

“Империо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

нөхөн сэргээлтийн эхний жилд хөрсний чийгийн горимыг барихын тулд хийх усалгааны тоо 7 хоногт 1 удаа, сард 4 удаа, жилд 15 удаа байна.

Хүснэгт 8. Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ

Шимт хөрсөөр хучилт эхлэх үеэс тоолсон хугацаа	Жилд нөхөн сэргээлт хийх талбай, м2	Хоногт усалгаанд шаардагдах ус, м3	Жилд хэдэн удаа услах	1 жилд, м3	Ундарга, л/сек
	120 ширхэг мод тарина	4.8	15	72.0	
	5000.0 мкв зүлэг ногоо	20.0	15	300.0	0.01
	Нийт			372.0	

5) Нийт усны хэрэглээ

Хүснэгт 9. Усны нийт хэрэглээний тооцоо

№	Үзүүлэлтүүд	Усны зарцуулалт				Усны эх үүсвэр
		м3/жил	м3/хон	л/сек		
1	Зам талбайн усалгаа	1-р жил	12116.4	87.8	1.016	Уурхайн шүүрлийн ус, үйлдвэрлэлийн хэрэглээний худгаас
	Нийт		12116.4	-	-	
2	Унд, ахуйн усны хэрэглээ	1-р жил	403.92	2.64	0.03	Өөрийн худгаас
	Нийт		403.92	-	-	
Биологийн нөхөн сэргээлт						

“Империо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

	Ногоон байгууламж 120ширхэг мод тарих	1-р жил	72.0	4.8		Уурхайн шүүрлийн ус
	5000.0 мкв зүлэг ногоо	1-р жил	300	20	0.01	Уурхайн шүүрлийн ус
Нийт			372.0	24.8	-	
Технологийн усны тооцоо						
2	Баяжуулах усны хэрэглээ	1-р жил	354800.0	-	-	Өөрийн худгаас 25%-ийг цэвэр усаар сэлбэнэ
Нийт			354800.0	-	-	
Технологийн 25% эргэлтийн цэвэр усны хэрэглээ						
4	Баяжуулах үйлдвэрт	1-р жил	87700.0	-	-	
Нийт			87700.0		-	-
Шүүрлийн ус						
5	Шүүрлийн ус	1-р жил	270,074.45	739.93	8.56л/с	

ТЭЗҮ-ээр нэг жилд олборлож дуусах бөгөөд нийт үйлдвэрлэлийн нөөцөөр 88.7 мян.м3 элс угаан баяжуулна. 1м3 элс баяжуулахад 4.0 м3 ус шаардлагатай гэж үзвэл нийт 354.8 мян.м3 ус болж байгаа ба үүний 75 хувийг эргэлтээр 25 хувийг нэмэлтээр шаардлагатай гэж үзвэл 87.7 мян.м3 нэмэлтээр сэлбэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл уурхайн үүсмэл нуурыг 0.003 л/сек-ээр усыг сэлбэж байх шаардлагатай байх бөгөөд үүнд дээрх зайлуулах усны ундарга хангалттай байна.

Жилд нийт хэрэглэх усны хэмжээ: 100,592.32 м3/жил буюу 657.46 м3/хон

Үйлдвэрлэлийн зориулалттай худаг 15 л/с буюу 1296м3/хон учраас усны ундарга хангалттай гэж үзлээ.

Худгийн координат	X	Y
1	101 18 24 33	45 48 27.53



Зураг 6. Худгийн байршил

Иймд технологийн усан хангамжыг ил уурхайн үүсмэл нуураас хангах бүрэн боломжтой байна.

Технологийн усны хэрэгцээг ордын шүүрлийн усыг татаж хангахаар төсөлд тусгасан байна. Жалга 2, Жалга 3 талбайд хийсэн 2021 оны Худгийн цооногийн өрөмдлөгийн судалгааны ажлын тайланд тусгасанаар шүүрлийн усны ундарга 15 л/сек болно.

Шүүрлийн усыг Бабушкины томъёогоор тодорхойлсныг оруулав.

Уурхайд шүүрэн орж ирэх усны тооцоо: 2021 оны нарийвчилсан хайгуулын судалгааны явцад сорилын туршилтаар гидрогеологийн параметруудийг тодорхойлсон байна. Ордын гидрогеологийн нөхцөлийг судлах зорилгоор ордын төв хэсгийн шавхалт туршилтын ажил гүйцэтгэж гидрогеологийн зарим үзүүлэлтүүдийг тодорхойлжээ.

1 дахь жилд ил уурхайд орж ирэх усны тооцоо

Ажлын явцад хайгуулын цооногуудаас 3.5-8.9м уст давхаргын зузаантай байна.

Ордын хэмжээнд зөвхөн доод цэрдийн ус бүрдэл нь уурхайд орох газрын доорх усны эх үүсвэр болох тул ордын хэмжээнд хийсэн шавхалтын ажлын үр дүнгээр уурхайн карьерт орох усны хэмжээг “Том худаг”-ийн /П.П. Климентов нар/ аргаар тооцоолсон болно.



$$Q_K = \frac{1.36 * K * m * m}{lg \frac{R}{r_0}}$$

$Q_K$ - ил уурхайд орж ирэх усны хэмжээ, м<sup>3</sup>/хоног

$K$ - шүүрэлтийн итгэлцүүр 25 м/хоног /Гидрогеологийн тайлан.,2013он/

$m$ - уст давхаргын дундаж зузаан 2.0 м

$R$ -нөлөөллийн радиус  $R=1.5 * \sqrt{0.22 * 10^3 * T} = 272.5$  м,  $T$ -уурхай ашиглах хугацаа 1 жилээр /150 хоног/ тооцов.

Энд:  $r_0$ -Ашиглалт явуулах талбайн радиус, м

$$r_0 = \sqrt{\frac{F}{\pi}} = \sqrt{\frac{100000.0}{3.14}} = 178.45$$

$F$ -Уурхайн талбайн нийт хэмжээ, м<sup>2</sup> /уурхай ашиглах хугацаа 1 жилээр тооцов/

Үүнд:

$$Q_K = \frac{1.36 * 25 * 2 * 2}{lg \frac{272.5}{178.45}} = 739.93 \text{ м}^3 / \text{хон} = 30.83 \text{ м}^3 / \text{цаг} = 8.56 \text{ л} / \text{с}$$

Эргэлтийн усан хангамжийн байгууламж, ус шүүрүүлэх суваг малтах

Усан сан. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны санг байгуулна. Усан сангийн багтаамж нь ажлын 5 хоногийн нөөцийг хангахад хүрэлцээтэй байна.

Хаягдлын сангийн багтаамж нь ойролцоогоор 10000 м<sup>3</sup> байна. Цэвэр усны сангийн хэмжээ 4500 м<sup>3</sup> байна. Уурхайн технологийн усан хангамжийн асуудлыг уст давхаргын усыг шүүрүүлэн эргэлтийн усан сан байгуулах замаар шийдвэрлэхээр төлөвлөж байна.

Технологийн усан хангамжийн үйл ажиллагаа нь тунгаагуур бүхий усан сан-уст давхаргаас шүүрсэн ус хуримтлуулах усан сан –ус шахах насос –угаах төхөөрөмж гэсэн схемээр явагдана. Ордыг олборлох ерөнхий зарчим нь хөрс хуулалт , элс олборлолтын ажил эхний шатанд хучдасын гадаад овоолготой, 2 дугаар шатнаас эхлээд дотоод овоолготойгоор явна.

Унд ахуйн ус цэвэршүүлэгч:

Усыг шууд ахуйн хэрэгцээнд хэрэглэж болохгүй ба цэвэршүүлэн хэрэглэх нь тохиромжтой гэж үзэн ус цэвэршүүлэх төхөөрөмж сонгож хөрөнгө оруулалтанд тусгав.

Хүснэгт 10. RO – 2000L/H маркын ус шүүгчийн техникийн үзүүлэлт

Загвар	RO – 2000L/H	
Ус шүүх хурд	2000 л/ц	
Чадал	7.3 кВт	
Хэмжээ	2200x1000x2300	

Ус ашиглах болон хаяж, зайлуулах зөвшөөрлүүд

Ус ашиглагчид нь ус ашиглах зөвшөөрөл хүсэж төрийн байгууллагуудад өргөдөл гаргах үүрэгтэй. Ус ашиглах зөвшөөрлийг 10 жилээр олгох ба 5.5 жилээр сунгана.

Хүснэгт 11. Ус ашиглах болон хаяж, зайлуулах, зөвшөөрлүүд

Өдөрт ашиглах ус	Ус ашиглах дүгнэлт гаргах байгууллага	Зөвшөөрөл олгох захиргааны байгууллага
0-50 м3	Аймгийн байгаль орчны байгууллага	Сумын засаг дарга
50-100 м3	Сав газрын захиргаа	Аймгийн байгаль орчны алба
100 м3 –аас дээш	Усны газар	Сав газрын захиргаа

Хаягдал ус зайлуулж, хаяж буй аж ахуйн нэгж, байгууллага бүр хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргах үүрэгтэй. Хаягдал усны хэмжээнээс шалтгаалан зөвшөөрлийг өөр өөр төрийн байгууллагууд үнэлж, олгох ажлыг хариуцна.

1.9 Ил уурхайн барилга байгууламж


“Империо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

Хүснэгт 12. Уурхайн эвдрэлд өртөх талбайн хэмжээ

№	Эвдрэл үүсэх талбай	Хэмжих нэгж	Хэмжээ	Эвдрэлийн шинж
1	Ил уурхай	га	14.6	Уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэгдэнэ.
2	Шимт хөрсний овоолго	га	2.09	Овоолго үүсгэж эвдэгдэнэ
3	Баяжуулах хэсэг	га	2.34	Угаах төхөөрөмж, Нуур, далан
4	Хөрсний гадаад овоолго	га	0.1	Ил уурхайн үйл ажиллагааны улмаас үүснэ.
5	Уурхайн тосгон, засварын цех	га	0.5	Барилга байгууламжийн улмаас эвдрэлд орно
6	Технологийн зам	га	4.39	Хөрс, элс тээврийн үед үүсэх технологийн зам
7	Бусад	га	2.0	Гар аргаар алт олборлогчдын улмаас эвдэрсэн газар
Нийт		га	26.02	

Төслийн эхний ашиглалтын жилд нийт 26.02 га талбай эвдрэлд өртөхөөр байна.

“Империо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан



Зураг 7. Уурхайн тосгоны зураг



Зураг 8. Газрын гадаргын ерөнхий төрх №1 2022.08.21



Зураг 9. Төслийн талбайн ерөнхий төрх -№2



Зураг 10. Төслийн талбайн ерөнхий төрх №3



Зураг 11. Төслийн талбайн ерөнхий төрх №4


## ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1 Байгаль орчны төлөв байдал

Судалгааны талбай нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын төвөөс урагш 19 км, Баянхонгор аймгийн Өлзийт сумын төвөөс зүүн урагш 46 км-т оршино.

**Газарзүйн онцлог:** Судалгааны талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай Хэнтийн уулархаг ихмуж, Хангайн мужийн Хангайн өмнөд бэгэлцэгийн тойрогт хамаарагдана. (Зураг №3)

Хангайн нурууны тойрог нь Монгол орны төв хэсэгт байрлах, 500 км үргэлжлэх томоохон уулт тогтолцоо бөгөөд гол нуруу нь баруун хойноос зүүн ургааш чиглэн тогтох бол салбар уулс нь түүнээсөөр чиглэлтэй байдаг. Хангайн нурууны хамгийн өндөр оргил нь уг нурууны баруун урд хэсэгт байрлах Отгонтэнгэр уул (д.т.д 4021 м) юм. Гол нуруу нь хойш ургааш чиглэсэн голуудын хөндийгөөр зүсэгдэж хэсэгчлэгдсэн, орой хэсэгтээ хад асга, чулуу ихтэй, ар ташлан нь ой модтой, өвөр ташлан нь огцом хэвгий байдалтай юм.



Зураг № 3. Талбайн физик газарзүйн мужлалын зураг

**Цаг уурын нөхцөл:** Нутаг дэвсгэрийн уур амьсгал бүрэлдэн тогтоход нөлөөлөх хүчин зүйлсийн дотроос газарзүйн байрлал ба газрын гадарга, нарнаас ирж буй цацраг илч, агаарын орчил хөдөлгөөн зэрэг бие биетэйгээ нягт холбоотой хүчин зүйл голчлон нөлөөлнө.

Судалгааны талбайн уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүдийг Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын цаг уурын харуулын 2015-2020 оны мэдээг ашиглан боловсрууллаа.

Судалгааны талбай орчмын газар нутаг нь ерөнхийдөө дулаан уур амьсгалтай, хур чийг багатай. Өвлийн улиралд гэнэтийн дулааралт бараг ажиглагддаггүй бол зуны улиралд гэнэтийн хүйтрэлт хааяа тохиолдоно. Агаарын температурын бас нэг онцлог бол хавар, намрын улирал богинохон, халуун хүйтний солилцоо эрс байдаг явдал юм.

Нарийнтээл сумын нутаг өндөр уул нуруу багатай газрын гадаргын хэв шинж бараг нэг төрлийн учраас байгалийн ба уур амьсгалын нөхцөл нь онцын ялгаагүй уур амьсгалын голлох үзүүлэлт хур тунадас температур ургамлын ургалтын хугацааны чийгийн хангамжийн үзүүлэлтийг уур амьсгалын мужлалын гол үзүүлэлт болгон авч болно.

Нарийнтээл сумын нутаг дэвсгэр нь уур амьсгалын хувьд чийглэгдүү сэрүүвтэр мужид хамрагдана.


Сүүлийн 6 жилийн мэдээллээр жилд дунджаар 86.8-243.8 мм тунадас, дулааны улиралд 163.5мм, хүйтний улиралд 12.8 мм тунадас тус тус орох ба чийгийн хүрлцээ ерөнхийдөө сайн байдаг. 1-рсарын агаарын дундаж температур  $-12.6^{\circ}\text{C}$  –  $-20.5^{\circ}\text{C}$  орчим хүйтэн, 7-р сарын агаарын дундаж температур  $17.8^{\circ}\text{C}$  –  $21.6^{\circ}\text{C}$  орчим дулаан байдаг ба жилийн хамгийн их дулаан байдаг  $30.7^{\circ}\text{C}$ , хамгийн бага нь  $-31.5^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрч байсан байна.

Энэ нутаг дэвсгэрт дундаж температур хавар 4-р сарын сүүлийн арав хоногоос 10 градусыг дайрч дулаардаг бөгөөд намар 9-р сарын эхний арав хоногт 10 градус болж цаашид буурдаг. Анхныхүйтрэл 9 дүгээр сарын 12-20-ны хооронд, эцсийн хүйтрэл 4-р сарын 19-24-ний хооронд тохиолдоно.

**Хөрсний шинж чанар:** Судалгааны талбайн орчны нутаг дэвсгэр нь хөрс газар зүйн мужлалаар Хангай их мужын Өндрийн бүсшилтэй нутгийн Хангайн мужийн Хангайн өврийн 43-р тойрогт хамаарагдана. (Монгол орны үндэсний атлас 2009).




“Имперо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН



Зураг № 24. Монгол орны хөрс-газарзүйн мужлалын зураг

Судалгааны талбайн ихэнх хэсэг 3030.7 га буюу 93.8 хувьд нь Цайвар хүрэн хөрс багахан хэсэгт 200.3 га буюу 6.2 хувьд нь Аллювийн нугын хөрс тархсан байна. Эдгээр хөрсний тархалтын талаартовч дурьдахын зэрэгцээ хөрсний зургаар харууллаа.

**Ургамал зүйн байдал:** Судалгааны талбай нь Монгол орны ургамалжилтын бүс, бүслүүрээр хээрийн болон цөлөрхөг хээрийн бүс-т хамаарна.



**Зураг № 42. Ургамалжилтын бүс бүслүүр**

**Хээрийн бүс:** Хуурайсаг өвслөг ургамал зонхилсон нутгийг хээр гэдэг. Монголын хээр нь Мажар улсын дунай “Пушти” хэмээх хээрээс Дорнод азийн манжуурын хээр хүртэл үргэлжлэх хээрийн дорнод хэсэг болно (Өлзийхутаг.Н, 1989). Хээрийн бүс нь Дорнод Монгол, Дундад Халхын

**“Империо майнинг” ХХК -ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Үзүүрт талбайн “Жалга 2”, “Жалга 3” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан**

тэгш өндөрлөг, өргөн уудам тал газрыг хамарч, баруун тийш нарийсан нарийссаар Хангайн нурууны өврийн нам уулсын бэлээр дамжин Ханхөхийн өмнөд бэл хүртэл нарийн зурвас газраар Их нууруудын хотгорт хүрч замхарна (Өлзийхутаг.Н, 1989). Хээрийн бүс д.т.д 950 м-1724 м өндөрт оршино. Хээрийн бүсийн урд хэсгээр эрт үед усан сав газар нилээд их талбайг эзлэж байсныг гэрчлэх сул барьцалдан тогтсон хайрга, элстэй эртний нууруудын хурдас ихээр тархсан байна. Хамгийн нам хэсэгт нь үлдэц нуур тойром, хужир мараа, шал тойром бүхий хотгор газар бүхий тэгшивтэр гадаргатай. Тэдгээр нь хоорондоо жижиг цав толгодоор тусгаарлагдана. Хөдөө аж ахуйн уур амьсгалын мужлалаар хүйтэн өвлийн хэв шинжтэй, ургамлын чийг хангамжийн нөхцлөөр чийг багатай, хуурайвтар, хуурай дэд бүсэд хамаарагдаж байна (Үндэсний атлас, 2009). Ургамал газарзүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн Дагуур Монголын хээрийн хошууны Дунд Халхын хээрийн тойрогт багтана.

11. **Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:** -
12. **Эзэмших газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:**

Эзэмшил газрын ангилал	Талбай, га	Үүнээс эвдэрч бохирдсон, талбайн хэмжээ, га		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшлийн газар	1027.27		-	-
Нэгж талбарын талбай	449.27			
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	-		-	-
А. Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	-	-	-	-
1. Үйл ажиллагаанд өртөөгүй	446.1528	-	-	-
Ургамлан нөмрөгтэй	446.1528	-	-	-
2. Үйл ажиллагаанд өртсөн	3.1172	3.1172	-	-
Үүнээс:				
Кемп	1.6788	1.6788	-	-
Хогийн цэг	0.7131	0.7131	-	-
Зогсоол	0.7253	0.7253	-	-
Б. Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай	-	-	-	-

**13. Газар ашиглалтын онцлог, гадаргын төлөв байдал:** Уулын цайвар хүрэн хөрс бүхий хэв шинжтэй экологийн нэгдүгээр нэгж талбар нь 449.27 га талбайтай байна. Энэхүү нэгж талбар нь уулын өвөр хэсэгт эзэмшил талбайн баруун өмнө хэсэгт байрлана. Газрын гадаргын тэгш бус, баруунаас зүүн тийш 0-3 орчим градусын налуутай, нэгж талбарын зүүн хэсэгт гуу жалгатай байна. Тус нэгж талбарт кемп (1.6788 га), зогсоол (0.7253 га га), хогийн цэг (0.7131 га) нийт хүний үйл ажиллагаагаар (3.1172 га) талбай дунд хүчтэй эвдрэлд өртсөн байна. Газрын гадаргад хужир мараа, намаг ажиглагдаагүй.

**14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл:** Уг нэгж талбарын баруун, зүүн хэсгээр уулын цайвар хүрэн хөрс хэсэгчлэн тархсан. Хөрсний ялзмагт үеийн зузаан нь янз бүр байдаг. Энэ нь газрын гадаргын хотгор гүдгэрээс хамаарна.

Ялзмагийн агууламж дээрээс доошлоход аажмаар багасаж байна. Хөрсний орчин ердийн нөхцөлд хүчиллэг буюу саармаг, карбонатын агууламж байнга ажиглагддаг байна (Д. Доржготов, 2003).

#### Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						Шавар
		Элс		Тоос				
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
1	0-20	39.1	33.8	11.8	2.0	6.7	6.5	15.3
3	0-20	31.1	42.7	10.9	10.9	2.8	1.6	15.3

Хөрсний механик бүрэлдэхүүнийг Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход зүсэлт нэг нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй зүсэлт гурав нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

#### Хөрсний химийн шинж чанар

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	pH H <sub>2</sub> O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзмаг %	CO <sub>2</sub>	NO <sub>3</sub> , мг/100 гр	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
1	0-20	8.12	0.055	0.022	1.43	0.96	0.43	9	8	3.6	9
3	0-20	8.45	0.061	0.024	1.52	1.12	0.54	11	9	3.0	10

**Дээж 01.** Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж хангамжтай, мөн хөдөлгөөнт фосфор маш бага, калийн агууламж дунд зэрэг байна. Хөрсний үржил шимийн түвшин дундаж байна. Ургамал ургах нөхцөл тааруу байгааг илтгэж байна.

**Дээж 03.** Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж дунд, мөн хөдөлгөөнт фосфор их, калийн агууламж дунд зэрэг байна. Хөрсний үржил шимийн түвшин дундаж байна. Ургамал ургах нөхцөл тааруу байгааг илтгэж байна.

#### Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
		Ni /никель/	Cd /кадмий/	Pb /Хар тугалга/	Zn /цайр/	Cr /хром/	Cu /зэс/
1	0-10	11.9	0.0	29.6	45.9	10.4	16.5
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		60.0	1.0	50.0	100.0	60.0	60.0
Хортой агууламж /MNS 5850:2019/		1000.0	10.0	500.0	600.0	400.0	500.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/		1800.0	20.0	1200.0	1000.0	1500.0	1000.0

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үзэхэд стандартын хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас бага байна.

#### Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

Үнэлгээ	Нянгийн тоо MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр MNS 5367:2004	Перфрингенсийн таньц MNS 6341:2012

	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Цэвэр	3.9*10 <sup>5</sup>	0.1	1	0.1<	1
Бохирдол багатай			0.1-0.01		0.1-0.01
Дунд зэргийн бохирдолтой			0.01-0.001		0.01-0.0001
Их бохирдолтой			0.0001		0.0001>

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

#### 15. Ургамлан нөмрөгийн төрх байдал, доройтол, талхагдлын хэлбэр:

Нэгж талбарт хялгана, хялгана-алаг өвст бэлчээрийн төрөл тархсан байна. Дэд зонхилогч нь хялгана ургамал байна. Нэгж талбарын баруун хэсэгт тархсан байна. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 85-90%, 100 м<sup>2</sup> талбайд 16 зүйл ургамал тархаж, ойролцоогоор 1.4 цн/га ургацтай. Ургамлын дундаж өндөр 3-45 см, сул талхлагдсан бэлчээр байна.

#### Ургамлан бүрхэвчийн төлөв байдал

Бэлчээрийн нэрийн төрөл	Ургамлан бүрхэвчийн төлөв байдал							
	Ургамлын бүрхэц, %		Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын зэрэг	Халцгай газар	Хад чулууны хэмжээ	Ургац, ц
	1м <sup>2</sup> талбайд	100 м <sup>2</sup> талбайд	1м <sup>2</sup> талбайд	100 м <sup>2</sup> талбайд				
Хялгана, хялгана-алаг өвст	85%	90%	4	16	бага	10	5	1.4

Тус ордын тусгай зөвшөөрлийн эзэмшил газар дахь ургамлан нөмрөг унаган төрхөө алдаагүй байна.

#### 16. Газар ашиглалтын аюулгүй байдал, техникийн нөхцөл:

Тус алтны шороон ордны зориулалттай талбайд өндөр хүчдэлийн шугам, усны эх үүсвэр гол байхгүй байна. Тус төслийн талбай нь орчны бохирдол байхгүй, газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй байна. Одоогоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

Цаашид үйл ажиллагаа явуулж эхлэх үед галын аюулгүй байдал болон хөдөлмөр хамгааллын хууль журмыг баримтлан ажиллах хэрэгтэй.

#### 17. Газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн талаар хийсэн дүгнэлт, цаашид авах арга хэмжээ, өгөх зөвлөмж:

Үзүүрт алтны шороон орд нь МУ-022144 тоот тусгай зөвшөөрөл бүхий 1027.27 га талбайтай. Тус уулын цайвар хүрэн хөрс нэгж талбарт кемп (1.6788 га), зогсоол (0.7253 га га), хогийн цэг (0.7131 га) нийт хүний үйл ажиллагаагаар (3.1172 га)

талбай дунд хүчтэй эвдрэлд өртсөн байна. Экологийн нэгж талбарын хувьд 2 төрлийн хөрс тархсан байна. Уулын цайвар хүрэн хөрс болон цайвар хүрэн хөрс тархсан байна. Уулын цайвар хүрэн хөрс бүхий хэв шинжтэй нэгж талбар нь 449.27 га талбайтай байна. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр хөрстэй байна. Хөрсний бохирдлын үзүүлэлтийг тодорхойлж (MNS 5850:2019) стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байна. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

Төслийн тусгай зөвшөөрөл бүхий нийт талбайн ургамлан нөмрөг нь экологийн нэгж талбарын хувьд хялгана, хялгана-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст гэсэн 2 нэгж талбарт хуваагдаж, үүнээс тус нэгж талбар нь хялгана, хялгана-алаг бэлчээрийн төрөл байна. Ургамлын бүрхэц 1м<sup>2</sup> 85-90%, 1м<sup>2</sup> талбайн зүйлийн бүрэлдэхүүн 4 зүйл байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн газрыг алтны шороон орд зориулалтаар ашиглахдаа дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журам, стандартыг хангаж ажиллах,
- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэгт заасны дагуу хог хаягдлаа ангилан ялгах, зориулалтын сав байрлуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, хөрс бохирдуулагч жорлон байгуулахгүй байх, хог хаягдлаа шатаахгүй байх,
- Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн ашиглалт дууссаны дараа газрын гадарга, хөрс, ургамлын анхны хэв шинж, төлөв байдалтай дүйцүүлэн стандартын дагуу нөхөн сэргээлт /техникийн болон биологийн/ хийх шаардлагатай. БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/138 дугаар тушаалын хавсралтад заасан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ыг дагаж мөрдөх,
- Шимт хөрсийг хуулахдаа Газар шорооны ажлын үед үржил-шимт хөрсний хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартыг мөрдөн ажиллах,
- Газрын тухайн хуулийн 58-р зүйл. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, түүнийг гаргах тухай заалтын дагуу газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт төлөвлөгөөт хянан баталгааг 5 жилд нэг удаа хийлгэх. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааг эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх шаардлагатай.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД  
УЛСЫН ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж. БАТСАЙХАН

**ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН  
БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ**

**Хянан баталгааны төрөл:** Захиалгат

**Огноо:** 2023.06.08

1. **Газар ашиглагч:** "Империо майнинг" ХХК
2. **Аймаг (нийслэл):** Өвөрхангай, Баянхонгор  
**Сум(дүүрэг):** Нарийнтээл, Өлзийт
3. **Байршил, хаяг:** Өвөрхангай аймаг Нарийнтээл, Баянхонгор аймаг Өлзийт сум
4. **Нэгж талбарын дугаар:** МУ-022144 -02
5. **Хөрсний нэр:** 64 Цайвар хүрэн
6. **Ургамалжилт:** У-III-1-1 Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст
7. **Нийт талбайн хэмжээ:** 578.0 га
8. **Газар эзэмших зориулалт:** Алт олборлолт
9. **Одоогийн газар ашиглалтын хэлбэр:** Алт олборлолт
10. **Газар ашиглах, эзэмших шийдвэр:** Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, Уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн МУ-022144 дугаар бүхий тусгай зөвшөөрөлтэй.
11. **Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:** -
12. **Эзэмших газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:**

Эзэмшил газрын ангилал	Талбай, га	Үүнээс эвдэрч бохирдсон, талбайн хэмжээ, га		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшлийн газар	1027.27	-	-	-
Нэгж талбарын талбай	578.0	-	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	-	-	-	-
А. Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	-	-	-	-
1. Үүнээс үйл ажиллагаанд өртөөгүй газар	578.0	-	-	-
Ургамлан нөмрөгтэй	578.0	-	-	-
2. Үйл ажиллагаанд өртсөн талбай	-	-	-	-
Б. Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай	-	-	-	-

**13. Газар ашиглалтын онцлог, гадаргын төлөв байдал:** Цайвар хүрэн хөрс бүхий хэв шинжтэй экологийн нэгж талбар нь 578.0 га талбайтай байна. Энэхүү нэгж талбар нь уулын өвөр хэсэгт эзэмшил талбайн зүүн хэсэгт байрлана. Газрын гадаргын тэгш бус, зүүнээс баруун тийш 3-5 орчим градусын налуутай, нэгж талбарын баруун хэсэгт гуу жалгатай байна. Үзүүрт алтны шороон орд нь МУ-022144 тоот тусгай зөвшөөрөл бүхий 1027.27 га талбайтай. Одоогоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

**14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл:** Уг нэгж талбарт цайвар хүрэн хөрс тархсан байна. Нэгж талбарын зүүн баруун хэсгээр хэсэгчилэн тархсан байна. Хөрсний ялзмагт үеийн зузаан нь янз бүр байдаг. Энэ нь газрын гадаргын хотгор гүдгэрээс хамаарна. Ялзмагийн агууламж дээрээс доошлоход

аажмаар багасаж байна. Хөрсний орчин ердийн нөхцөлд хүчиллэг буюу саармаг, карбонатын агууламж байнга ажиглагддаг байна (Д. Доржготов, 2003).

#### Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						Шавар
		Элс		Тоос				
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
4	0-28	28.3	51.3	4.2	4.7	7.3	4.2	16.2

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход зүсэлт нэг нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

#### Хөрсний химийн шинж чанар

Дээжний дугаар	Гүн, см	pH H <sub>2</sub> O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзмаг %	CO <sub>2</sub>	NO <sub>3</sub> , мг/100 гр	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
4	0-28	8.20	0.057	0.023	2.06	0.96	0.35	11	9	3.0	10

**Дээж 04.** Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж дунд, мөн хөдөлгөөнт фосфор маш бага, калийн агууламж дунд байна. Хөрсний үржил шимийн түвшин дундаж байна. Ургамал ургах нөхцөл тааруу байна.

#### Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
		Ni /никель/	Cd /кадмий/	Pb /Хар тугалга/	Zn /цайр/	Cr /хром/	Cu /зэс/
4	0-10	10.6	0.0	29.6	62.6	8.6	23.5
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		60.0	1.0	50.0	100.0	60.0	60.0
Хортой агууламж /MNS 5850:2019/		1000.0	10.0	500.0	600.0	400.0	500.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/		1800.0	20.0	1200.0	1000.0	1500.0	1000.0

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үзэхэд стандартын хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас бага байна.

#### Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

Үнэлгээ	Нянгийн тоо MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр MNS 5367:2004			Перфрингенсийн таньц MNS 6341:2012	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	
Цэвэр	3.9*10 <sup>5</sup>	0.1	1	0.1<	1	
Бохирдол багатай			0.1-0.01		0.1-0.01	
Дунд зэргийн бохирдолтой			0.01-0.001		0.01-0.0001	

Их бохирдолтой			0.0001		0.0001>
-------------------	--	--	--------	--	---------

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

#### 15. Ургамлан нөмрөгийн төрх байдал, доройтол, талхагдлын хэлбэр:

Жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст төрөл тархсан байна. Дэд зонхилогч нь жижиг дэгнүүлт үетэнх зүйл байна. Нэгж талбарын зүүн хэсэгт тархсан байна. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 90%, 100 м<sup>2</sup> талбайд 6 зүйл ургамал тархаж, ойролцоогоор 1.2 цн/га ургацтай. Ургамлын дундаж өндөр 3-24 см, сул талхлагдсан бэлчээр байна.

#### Ургамлан бүрхэвчийн төлөв байдал

Бэлчээрийн нэрийн төрөл	Ургамлан бүрхэвчийн төлөв байдал							
	Ургамлын бүрхэц, %		Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын зэрэг	Халцгай газар	Хад чулууны хэмжээ	Ургац, Ц
	1м <sup>2</sup> талбайд	100 м <sup>2</sup> талбайд	1м <sup>2</sup> талбайд	100 м <sup>2</sup> талбайд				
Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст	82%	90%	7	12	бага	8	10	1.2

Тус ордын тусгай зөвшөөрлийн эзэмшил газар дахь ургамлан нөмрөг унаган төрхөө алдаагүй байна.

**16. Газар ашиглалтын аюулгүй байдал, техникийн нөхцөл:** Тус алтны шороон ордны зориулалттай талбайд өндөр хүчдэлийн шугам, усны эх үүсвэр гол байхгүй байна. Тус төслийн талбай нь орчны бохирдол байхгүй, газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй байна. Одоогоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

Цаашид үйл ажиллагаа явуулж эхлэхдээ галын аюулгүй байдал болон хөдөлмөр хамгааллын хууль журмыг баримтлан ажиллах хэрэгтэй байна.

#### 17. Газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн талаар хийсэн дүгнэлт, цаашид авах арга хэмжээ, өгөх зөвлөмж:

Үзүүрт алтны шороон орд нь МУ-022144 тоот тусгай зөвшөөрөл бүхий 1027.27 га талбайтай. Одоогоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна. Экологийн нэгж талбарын хувьд 2 төрлийн хөрс тархсан байна. Уулын цайвар хүрэн цайвар хүрэн хөрс тархсан байна. Экологийн нэгж талбар хуваах зарчмын цайвар хүрэн хөрс нь 578.0 га байна.

Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр хөрстэй байна. Хөрсний бохирдлын үзүүлэлтийг тодорхойлж (MNS 5850:2019) стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байна. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.



Ургамалжлын хувьд жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээрийн төрөл байна. Ургамлын бүрхэц 1м2 82-90%, 1м2 талбайн зүйлийн бүрэлдэхүүн 3 зүйл байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн газрыг алтны шороон орд зориулалтаар ашиглахдаа дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журам, стандартыг хангаж ажиллах,
- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэгт заасны дагуу хог хаягдлаа ангилан ялгах, зориулалтын сав байрлуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, хөрс бохирдуулагч жорлон байгуулахгүй байх, хог хаягдлаа шатаахгүй байх,
- Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн ашиглалт дууссаны дараа газрын гадарга, хөрс, ургамлын анхны хэв шинж, төлөв байдалтай дүйцүүлэн стандартын дагуу нөхөн сэргээлт /техникийн болон биологийн/ хийх шаардлагатай. БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралтад заасан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ыг дагаж мөрдөх,
- Шимт хөрсийг хуулахдаа Газар шорооны ажлын үед үржил-шимт хөрсний хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартыг мөрдөн ажиллах,
- Газрын тухайн хуулийн 58-р зүйл. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, түүнийг гаргах тухай заалтын дагуу газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт төлөвлөгөөт хянан баталгааг 5 жилд нэг удаа хийлгэх. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааг эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх шаардлагатай.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД  
УЛСЫН ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж. БАТСАЙХАН



Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн  
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар **0013152**

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: *"Центро.Майнинг" ХХУ*

Хаяг *Өвөрхангай Нийслэлийн төвд суурь II баг /Ч.Бүтээгч/*  
*2020 онов*

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: *Ажлын үйлдвэр*

*Орон сууцны гал тусгаарлах зориулалттай*

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.

/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/

/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Олгосон: *2023* он *11* сар *15* өдөр

Хүчинтэй хугацаа: *2025* он *11* сар *15* өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

*Өвөрхангай* аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/  
дарга *Б.Батбаяр* цолтой *Б.Батбаяр*

Дүгнэлт гаргасан:

*Өвөрхангай* аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/  
Гал түймрийн улсын хяналтын байцаагч: *А.М.М.* цолтой *Б.Батжиган*



## САНАМЖ

Галын аюулгүй байдлын дүгнэлтийг үйлчилгээний танхимд хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь үнэт цаас учраас үрэгдүүлж, гэмтээлгүй хадгалахаас гадна хувилж, олшруулж, хуурамчаар үйлдвэрлэсэн болон бусдад түрээслэх, худалдсан тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь банкны зээлийн баталгаа, барьцаа болохгүй.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан норм, дүрэм, стандартыг зөрчсөн тохиолдолд Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан хураан авах, цуцлах эрхтэй.

Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссанаас хойш 1 сарын хугацаанд дахин сунгуулах.



Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн  
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0006759

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: *"Циперо майнинг" ХХК*

Хаяг: *Өвөрхангай Нэрлийн тээвэр Г.М. II Бал /үзчирлэл/*  
*гэвч гэвэр*

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: *цэвэрлэгүүн*

*төвөр, жингийн борлуулалт*

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.  
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2/  
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Олгосон: *2023* он *11* сар *15* өдөр

Хүчинтэй хугацаа: *2025* он *11* сар *15* өдөр хүртэл

Дүгнэлт олгосон: *Өвөрхангай* аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/  
дарга *Дэгд дурандас* цолтой *Одонбаяр*

Дүгнэлт гаргасан: *Өвөрхангай* аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/  
Гал түймрийн улсын хяналтын байцаагч *Охид* цолтой *В. Балжин нвс*



/тэмдэг дарна/



## Шалгалт хийсэн тухай тэмдэглэл

№	ШАЛГАХ ЧИГЛЭЛ	ХАМРАХ ХҮРЭЭ	ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН	СТАНДАРТ ДҮРЭМ НОРМЫН ШААРДЛАГА	ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХ
1.	Барилга байгууламжид байгаа гал унтраах болон галаас сэргийлэх тоног төхөөрөмж	Гал унтраах автомат тоног төхөөрөмж			
		Галын дохиололын систем			
		Утаа зайлуулах систем			
		Аврах хэрэгсэл			
2.	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл	Гал унтраагуур			
		Галын саравч			
		Бусад			
3.	Галаас хамгаалах болон гал унтраах бодис материал	Гал унтраах усан хангамж			
		Гал унтраах хөөс			
		Галаас хамгаалах түрхлэг/ нэвчилгээ			
4.	Бусад	Авралтын зам гарцын тэмдэг, тэмдэглэгээ			
		Бусад			

Шалгасан:

Гал түймрийн улсын хяналтын байцаагч

..... цолтой.....

БАТЛАВ:  
“ИМПЕРО МАЙНИНГ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТЦЭЦЭГ



БАТЛАВ:  
“АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Р.БАЯРБАТ



**ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС, ТОСОЛГООНЫ ШИНГЭНИЙ ХАЯГДАЛЫГ  
ҮҮСГЭГЧ НЬ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ГЭРЭЭ**

№

2023 оны 11-р сарын 07 -ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Техникийн хаягдал тос, тосолгооны шингэн хаягдалыг хүлээлгэн өгөх гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчин гудамж, Пеарл тауэр 704 тоот хаягт байрлах **6613713** тоот регистрийн дугаар бүхий “Империо майнинг” ХХК /цаашид “**Үүсгэгч**” гэх/-ийг төлөөлж Ерөнхий геологи албан тушаалтай Борхүү овогтой Бүтэмж нөгөө талаас Улаанбаатар хот Багахангай дүүрэг 1-р хороо химийн гудамжинд байрлах **5537266** регистрийн дугаартай “Алтан Оршихуй Групп” ХХК /цаашид “**Боловсруулагч**” гэх/-ийг төлөөлж Хангамж, борлуулалтын менежер албан тушаалтай Д.Ариунмөрөн нар /хамтад нь “Талууд” гэх/ Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, байгаль орчины нөлөөлөх байдлын багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үүсгэгч нь өөрийн үйлдвэр, уурхайгаас гарах техникийн ашигласан тос, тосол, гидрийн шингэн болон бусад тосолгооны шингэний хаягдал /цаашид “**Хаягдал тос**” гэх/-ийг холбогдох дүрэм, журмын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэн Үүсгэгчээс Боловсруулагчид шилжүүлэх, Боловсруулагч нь хүлээн авах, устгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хаягдал тос нь хог хаягдлын ангилалын төрлөөр аюултай хог хаягдлын **A** зэрэглэлд \БОАЖЯСайдын А/349 тоот кодчилсон жагсаалтанд\ багтсан байгаль орчинд хор аюулын чанартай шингэн хог хаягдал юм.
- 1.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ байгаль орчны бохирдол гаргахгүй, галын аюулгүй байдлыг бүрэн сахиж, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд үйл ажиллагаа явуулах шаардлагатай.
- 1.4. Энэхүү гэрээнд талууд нөгөө талынхаа хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах зарчмыг баримтална.
- 1.5. Энэхүү гэрээний Хавсралт №1-т Үүсгэгчийн хаягдал тос цуглуулах, хадгалах үйлдвэр, уурхайн жагсаалт, **сард гарах хаягдалын хэмжээ, төрлийг бүрэн тодорхойлж** хавсаргах бөгөөд энэхүү хавсралт нь гэрээний салшгүй нэгэн гол хэсэг байна.

**Хоёр. Гэрээний хугацаа**

Гэрээ нь 2023 оны 11-р сарын 07 -ний өдрөөс 2024 оны 11-р сарын 07 -ний өдөр хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

- 1.2 Гэрээний хугацааны хэрэгжилтийг хоёр тал харилцан үйл ажиллагаа зохистой явагдсаныг хянан, дүрэм журмын биелэлтийг дүгнэж, сунгах саналыг шийдвэрлэнэ.
- 1.3 Гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан дүгнэлтэнд дараах зүйлийн биелэлтийг дүгнэнэ. Үүнд:
  - 1.3.1 Энэхүү гэрээний баталгаанд Үүсгэгч нь өөрийн эзэмшлийн талбай дээрх хог хаягдалын кодчилсон жагсаалтын 13-р бүлгийн аюултай хаягдалын төгрөгт тооцон жилд нийлүүлэх хаягдалаас хамааран 800.000 “**Гэрээний төлбөр**” болгож Боловсруулагчид байршуулах.
  - 1.3.2 “Гэрээний төлбөр” нь тухайн жилд хүлээлгэн өгөх аюултай хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах, хоргүйжүүлэх үйлчилгээний хөлс бүрэн багтана. Энэхүү төлбөр нь тухайн жилдээ хүчинтэй байна.

- 1.3.3 Үүсгэгч нь гэрээний тохиролцсон хугацаанд хаягдал тосыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолыг үүсгэхгүй байхад анхаарч, хоёр тал хариуцлагатай, шударга зарчмыг баримтлана.
- 1.3.4 “Гэрээний төлбөр”-г баримтжуулахад санхүүгийн болон хаягдалын тухай 13.4 заалт тодорхойлох, 6.2.4-ийн дагуу бүх зохицуулалтыг хоёр тал хуулийн дагуу хэрэгжүүлнэ.
- 1.4 Талууд гэрээг цуцлах саналаа ажлын 10 хоногоос доошгүй хугацаанд нөгөө талдаа бичгээр мэдэгдэх бөгөөд шийдвэрийг хамтран гаргана.
- 1.5 Аль нэг талаас гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн буюу удаа дараа гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг нэг талын санаачлагаар цуцалж болно.

#### **Гурав. Үнэ, төлбөрийн нөхцөл**

- 3.1 Үүсгэгчийн хүлээлгэн өгөх Хаягдал тосны үнэ нь 1 литр тутамд “0” төгрөг /Тэг төгрөг/ байна.
- 3.2 Хоёр талд Аюултай хог хаягдалын жагсаалтын 13-р бүлгийн хаягдалыг үнэлэх ёс зүйн ашиг сонирхол байхгүй байна.
- 3.3 Энэхүү гэрээний хугацаанд хэдэн удаа тээвэрлэлт хийхийг талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 3.4 Хаягдал тосны шинжилгээний лабораторийн дүнг үндэслэн ус, механик хольцийн үлдэгдэлийн хэмжээг хаягдал тосны баримтын дүнгээс хасалт хийж хаягдал тос хүлээн авсан маягт А\21 05-р хавсралтаар *“Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн батлагдсан”* бүртгэлд хөтөлнө.
- 3.5 Үүсгэгч нь “Империо майнинг” ХХК-ийн төслийн талбайд стандарт нормын дагуу хадгалж, цуглуулж, тээвэрлэн хүлээлгэн өгнө.

#### **Дөрөв. Хаягдал тос ачих, тээвэрлэх, хүлээлгэн өгөх, хүлээн авах**

- 4.1 Хоёр тал эрх бүхий байгууллагаас баталсан аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх аюулгүй болгох, хадгалах устгах журмыг дагаж мөрдөх;
- 4.2 Үүсгэгч нь өөрийн төслийн талбайгаас хаягдал тосыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх аюулгүй ажиллагааг бүрэн хариуцна.
- 4.3 Үүсгэгч нь төслийн талбайгаас хаягдал тосыг зориулалтын хуримтлуулсан ёмкость савнаас зориулалтын тээврийн машинд тээвэрлэх, тээврийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдох үйлчилгээний хөлсийг бүрэн хариуцна.
- 4.4 Талууд энэ гэрээний дагуу хаягдал тос хүлээн авах, хүлээлгэн өгөхдөө савны битүүмжлэлийг шалгаж, акт үйлдэн хүлээн авна. Актанд талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж 2 хувь үйлдэнэ.
- 4.5 Хэрэв хаягдал тос тээвэрлэх сав, хаягдал тосны үндсэн шинж чанарт бүрэн нийцэмжгүй, хэсэгчилсэн дээжинд химийн бодисын орц найрлагын шинж илэрсэн болон шинж чанарт тохироогүй үйлдэл байгаа болох нь тогтоогдвол Боловсруулагч нь хүлээн авахаас хэсэгчилсэн болон бүхэлд нь татгалзах эрхтэй.
- 4.6 Талууд энэ гэрээний 4.1-т заасны дагуу шалгаж акт үйлдсэнээр хаягдал тостой холбоотой бүх эрсдэл Боловсруулагч талд шилжинэ. Боловсруулагч нь ийнхүү хүлээн авсанаас хойшхи үүсэх аливаа эрсдэлийг /дахин боловсруулах бүх үе шатанд/ бүрэн хариуцна.
- 4.7 Үүсгэгч нь хаягдал тосны тээвэрлэлтийг гуравдагч этгээдээр хариуцуулан гүйцэтгүүлэх тохиолдолд энэхүү гэрээний бүх зүйл заалт нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

#### **Тав. Үүсгэгчийн эрх, үүрэг**

- 5.1 **Үүсгэгч нь дараах үүрэгтэй:**
  - 5.1.1 Хаягдал тосыг хүлээлгэн өгөхдөө гэрээний 4 дүгээр зүйлд заасны дагуу акт үйлдэн баталгаажуулж, Боловсруулагчийн төлөөлөгчөөр гарын үсэг зуруулж авах;
  - 5.1.2 Хаягдал тосны хуримтлалын сав нь шингэн аюултай хаягдал хадгалах бүтээгдэхүүний стандартад нийцсэн, битүүмж алдагдаагүй газарт хадгалах;
  - 5.1.3 Үүсгэгч нь Боловсруулагчид хаягдал тосны хуримтлагдсан тоо хэмжээг 5-7 хоногийн өмнө мэдэгдэж, тээвэрлэлт хийх хугацааг тогтоох;
  - 5.1.4 Хаягдал тосыг хүлээлгэн өгөхдөө Боловсруулагчийн “Алтан Оршихуй групп” ХХК-ийн байгаль орчин, ХАБЭА-н шаардлагуудыг биелүүлэх;
  - 5.1.5 Үүсгэгч нь Хууль болон гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх;
  - 5.1.6 Үүсгэгч нь Боловсруулагчтай гэрээ байгуулснаас хойш өөр бусад этгээдэд хаягдал тос нийлүүлэхгүй байх, эсхүл өөрөө устгахгүй байх үүрэгтэй.

5.1.7 Боловсруулагчийн хэвийн үйл ажиллагаанд аль болох саад учруулахгүй байх нөхцөлийг сонгож ажиллах бөгөөд Боловсруулагчийн төслийн талбай, тусгай бүсэд хориглосон газар тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хэрэглэсэн байдалтай нэвтрэх, эмх замбараагүй байдал үүсгэхийг ажилтнууддаа хориглох, тийм байдал үүсэхээс сэргийлж ажиллах;

**5.2 Үүсгэгч нь дараах эрхтэй:**

5.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

5.2.2 Боловсруулагч талд санал хүсэлтээ мэдэгдэж шийдвэрлүүлэх;

5.2.3 Энэ гэрээний Хавсралт №1-т заасан цэгийг хүссэн тоогоор харилцан нэмэх;

5.2.4 Хууль болон гэрээнд заасан бусад эрх;

**Боловсруулагчийн үүрэг, эрх**

**6.1 Боловсруулагч нь дараах үүрэгтэй:**

6.1.1 Боловсруулагч нь хаягдал тосыг хүлээн авсанаар дүн шинжилгээ хийх, боловсруулах, устгах үйл ажиллагааг хариуцна.

6.1.2 Боловсруулагч нь гэрээний дагуу хүлээн авсан аюултай хог хаягдлыг устгах тохиолдолд тусгайлан бэлтгэсэн талбай, зориулалтын тоног төхөөрөмж, эсхүл байгууламж бүхий зөвшөөрөгдсөн цэгт аюулгүй болгон устгах;

6.1.3 Хаягдал тосыг дахин боловсруулахдаа хүрээлэн буй байгаль орчныг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

6.1.4 Хаягдал тосыг Үүсгэгчийн мэдэгдсэн хугацаанд хүлээн авах, Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хоногийн хоцролт гарах үед тухай бүр урьдчилан мэдэгдэх; .

**6.2 Боловсруулагч нь дараах эрхтэй:**

6.2.1 Санал хүсэлтээ Үүсгэгчид мэдэгдэж шийдвэрлүүлэх;

6.2.2 Үүсгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.

6.2.3 Үйлдвэрийн лабораторийн дүгнэлтийг үндэслэн механик хольц, усны хорогдлыг тооцон актад тусгана.

6.2.4 Учирсан хохирлоо үүсгэгчээс шаардах

6.2.5 Хууль болон гэрээнд заасан бусад эрх

**Долоо. Талуудын хүлээх хариуцлага**

7.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих журмын дагуу гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа хохирол учруулсан бол учирсан бодит хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Бодит хохирол гэдэгт хохирогч талд учирсан шууд хохирол болон түүний гуравлагч этгээдийн өмнө хүлээсэн хариуцлагыг ойлгоно.

7.2 Үүсгэгч нь Боловсруулагчид урьдчилан мэдэгдээгүйн улмаас техник тоног төхөөрөмжийг урьдчилан бэлтгээгүй, заавар зааварчилгаа аваагүй, хяналт тавиагүй, машин орох талбайг бэлтгээгүй, хүлээлгэн өгөхдөө хайхрамжгүй хандсан, хяналт сулруулсан улмаас гарах хохирлыг бүрэн хариуцна.

**Найм. Давагдашгүй хүчин зүйл**

8.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гэрээний талуудын хүсэл зоригоос гадуур гэрээний үүргийн гүйцэтгэлд саад болох хүчин зүйлийг ойлгоно. Энэхүү хүчин зүйл гэдэгт иргэний бослого, үймээн, зэвсэгт мөргөлдөөн, хорно цээр, үйлдвэрлэлийн талаарх засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээ болон байгалийн давагдашгүй хүчин зүйлс болох салхи шуурга, гал түймэр, газар хөдлөлт, үер зэрэг гамшигт нөхцөл байдал хамаарна. Энэхүү гэнэтийн болон давагдашгүй хүчний нөлөөллөөс болж талууд үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд тус хугацаагаар гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх хугацаа сунгагдах ба энэ тохиолдолд аль ч тал хариуцлага хүлээхгүй. Ийнхүү гэнэтийн болон давагдашгүй хүчний нөлөөлөл болсон гэдгийг талууд баримтаар баталгаажуулах үүрэгтэй.

8.2 Хэрэв Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс зохих ёсоор гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдалд орсон бол нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

**Ес. Маргаан шийдвэрлэх**

9.1 Энэхүү Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үүргийн гүйцэтгэл болон хуулийн дагуу үүсч болох бүхий л үүргийн гүйцэтгэлтэй холбоотой аливаа маргааныг гэрээний талууд нэн тэргүүнд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.



- 9.2 Талууд харилцан тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Монгол улсын шүүхээр хянан шийдвэрлүүлнэ.
- 9.3 Энэ гэрээ нь Монгол Улсын хуулийн дагуу үйлдэгдсэн ба тэдгээр хуулийн хэм хэмжээнд тайлбарлагдан ойлгогдоно.

**Арав. Мэдээлэл хүргүүлэх**

- 10.1 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа мэдэгдэл, санал хүсэлтийг бичгэн хэлбэрээр, эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдэгтэйгээр үйлдэн доорх хаягаар хүргүүлнэ. Үүнд:

**Үүсгэгчид хүргүүлэх бол:**

Нэр: "Империо майнинг" ХХК  
Албан тушаал: Ерөнхий геологи  
Хаяг:

- 10.1 дэх хэсэгт заасан мэдээлэлдээ өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүйгээс үүссэн аливаа хохирол, зардлыг мэдэгдээгүй тал нь бүрэн хариуцна.

**Арван нэг . Бусад зүйл**

- 11.1 Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 11.2 Энэхүү гэрээ хэрэгжих явцад гэрээнд аливаа нэмэлт өөрчлөлт оруулах, нэмэлт гэрээ байгуулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 11.3 Энэхүү Гэрээг Монгол хэл дээр бичгээр 1 хувь үйлдэх бөгөөд Үүсгэгчид 1 хувь, Боловсруулагчид 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн ижил хүчинтэй байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**Үүсгэгч талыг төлөөлж:**

"Империо майнинг" ХХК-ийн  
Ерөнхий геологич Б.Бүтэмж  
Холбогдох утас:99078072

.....  
*Бүтэмж*

**Боловсруулагч талыг төлөөлж:**

"Алтан Оршихуй Групп" ХХК-ийн  
Менежер Д.Ариунмөрөн  
Холбогдох утас:91918550

.....  
*Д.Ариунмөрөн*

**Үүсгэгчийн талын харилцах албан  
тушаалтаны мэдээлэл**


№	Албан тушаал	Овог нэр	Холбогдох утас	Е майл	Үйл ажиллагаа
1.	Ерөнхий Геологич	Б.Бүтэмж	99078072	butemj@gmail.com	Ачилтын хуваарь зохицуулах, дээж авч илгээх
2.	Механик	О.Батхүү	99051668		

**Боловсруулагчийн талын харилцах албан  
тушаалтаны мэдээлэл**

№	Албан тушаал	Овог нэр	Холбогд утас	Е майл	Үйл ажиллагаа
1	Хангамжийн менежер	Д.Ариунмөрөн	91918550	<a href="mailto:Gug.ariunmoron@gmail.com">Gug.ariunmoron@gmail.com</a>	Ачилтын хуваарь зохицуулах Таталт хийх
2	Нягтлан бодогч	М.Халиун	98457888	<a href="mailto:gug.haliun@gmail.com">gug.haliun@gmail.com</a>	

**ХАВСРАЛТ БАТАЛСАН:**

**Үүсгэгч талыг төлөөлж:**  
“Импери майнинг” ХХК-ийн  
Ерөнхий геологич Б.Бүтэмж  
Холбогдох утас:99078072

  
.....

**Боловсруулагч талыг төлөөлж:**  
“Алтан Оршихуй Групп” ХХК-ийн  
Менежер Д.Ариунмөрөн  
Холбогдох утас:91918550

  
.....

БАТЛАВ  
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б СУГАР

2023 оны 01 сарын 01 өдөр

### ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2023 оны 01 сарын 01 өдөр

№

Цагаан-Овоо

#### НЭГ. Нийтлэг үндэслэл

Монгол улсын байгаль хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн 17-р дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 6.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйлүүдийг үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллах амьдрах орчыг бий болгоход оршино.

#### Хоёр. Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын ЗДТГ-ыг төлөөлж ЗДТГ-ын дарга Б.Сугар нөгөө талаас "Импери майнинг" ХХК-ний гүйцэтгэх захирал Б.Батцэцэг нар харилцан тохиролцож 2023 оны 01-р сарын 01-ны өдрөөс 2023 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

#### Гурав. Төлбөр тооцсон байдал

26 хүнтэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд бэлтгэл ажил гүйцэтгэлийн хугацааг дуустал төлбөрийг тооцов.

Ажиллах хугацаа: 06 сар

Жилийн төлбөр: 1.060.800 төгрөг

#### Дөрөв. Сумын ЗДТГ-ын эрх үүрэг

- Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих
- Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах

#### Тав. Аж ахуй нэгжийн эрх үүрэг

- Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн, хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх
- Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө гэрээнд зааснаар Төрийн сангийн ..... тоот дансанд шилжүүлсэн байна
- Хог хаягдлыг ангилан ялгаж байх
- Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх
- Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын ЗДТГ-г мэдээлж байх
- Хог хаягдлыг ангилах талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах
- Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох
- Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн тараар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх


**Зургаа. Гэрээний хариуцлага**

Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийднэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Нарийнтээл сумын ЗДТГ-ын  
байгаль орчин хариуцсан мэргэжилтэн



Имдэрэ Майринг ХХК-ний  
Гүйцэтгэх захирал



Б.Батцэцэг /

гарын үсэг, тамга